

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	11
3.1	ЦАЛИНГИЙН ДАНСНЫ ТАЛААР.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2	ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААР .	<b>Error! Bookmark not defined.</b>
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийнтайлан .....	21
4.7	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.22 № 06/211  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН  
ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүүхдийн төв номын сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2019\0222SAG9.Docx


070453

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүүхдийн төв номын сангийн дарга Д.Оюунбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 6-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Од Бүртгэл Аудит ХХК-ийн Н.Дагийрагчаа ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Од бүртгэл Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хүүхдийн төв номын сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хүүхдийн төв номын сан нь хүүхэд, залуучуудад төрөл бүрийн ном, хэвлэл, мэдээллээр үйлчилж ард түмнийг соён гэгээрүүлэх хөтөч нь байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2004.09.15-ны өдрийн 196 дугаар тогтоолоор хүүхэд залуусыг ном, хэвлэлээр хангах тэдний мэдлэг, хэрэгцээнд зориулсан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий бие даасан байгууллага болгон өргөжүүлсэн. Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтэд үйлчлэх 6 танхим, хүүхэд залуучуудад үйлчлэх 1 зөөврийн номын сангаар дамжуулан:
  - Уншлагын танхимын үйлчилгээ;
  - Гэрээр ном олгох үйлчилгээ;
  - Зөөврийн номын сангийн үйлчилгээ;
  - Цахим номын сангийн үйлчилгээ;
  - Соёл, олон нийтийн ажил;
  - Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ; ба

- Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус үзүүлж байна.

2. Ерөнхий удирдлага, арга зүйн хүрээнд:

- Хүүхдийн төв номын сангийн сан хөмрөгийг шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах;
- Хүүхдийн төв номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх; ба
- Хүүхдийн ном, хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Хүүхдийн төв номын сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хүүхдийн төв номын сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Соёлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль; ба
- Номын сангийн тухай хууль.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн шимтгэлийн хувь хэмжээнд болон ХХОАТ-ын тухай хуулийн хөнгөлөлтийн хэмжээ шатлалтай болж өөрчлөлтүүд орсон бөгөөд оны эхнээс мөрдөгдөж байгаа.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа БСШУС-ын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хүүхдийн төв номын сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүүхдийн төв номын сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн “Acolous”, Цалингийн “Payroll” болон Номын сангийн “Lib4” зэрэг програм хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүүхдийн төв номын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд *Дунд* гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт *Үр нөлөөтэй* гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хүүхдийн төв номын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллагын хувьд төсвийн зарцуулалтын асуудал санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд илүү чухал ач холбогдолтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны ***Нийт зардал*** 519,887.18 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох **5,198.87** мянган төгрөгөөр материаллагийн түвшинг тооцсон.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь сонгосон суурь үзүүлэлтийн эрсдлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр 7 асуудалд аудитын 13 горим сорил төлөвлөн гүйцэтгэж, мөн гүйцэтгэлийн шатанд дээрх чиглэлүүдэд хамаарах 3 асуудлыг нэмэлтээр тодорхойлон аудитын 3 горим сорилыг батламж мэдэгдлийн хүрээнд тус тус хэрэгжүүлсэн. Аудиторын илрүүлсэн нийт 10 асуудлаас 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж 1 алдааг 2019 онд залруулуулахаар зөвлөмж өглөө.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30101, В30102, В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	260.46	Уг алдааг 2019 онд суутган залруулахаар зөвшөөрсөн.
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>260.46</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитын гүйцэтгэлийн үед илэрсэн залруулагдах боломжтой 4 алдааг тайлан эцэслэж гаргахаас өмнө залруулсан.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хүүхдийн төв номын сангийн төсвийн захирагч нь 2018 онд 516,582.20 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаагаар 6,500.00 төгрөгийн орлого олохоор төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 519,977.17 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалингийн зардал 3,184.15 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Хүүхдийн төв номын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. [www.shilendans.gov.mn/org/1152](http://www.shilendans.gov.mn/org/1152)

Шилэн дансанд:

2018 оны 1-12 сарын батлагдсан төсөв;

2018 оны 1-12 төсвийн гүйцэтгэлийн мэдээ;

2018 онд төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хэтрэлт хэмнэлтийн мэдээ;

2018 оны цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг тус тус байршуулсан байна.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 95 хувьтай байна.

2017 оны Санхүү төсвийн тайланд Од Бүртгэл Аудит ХХК-аас хийсэн аудитаар 2 чиглэлд 4 зөвлөмж өгсний 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжид бага хэмжээний алдаа гарч хараахан бүрэн хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд аудитын гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүүхдийн төв номын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг, ахлах нягтлан бодогч Г.Оюунтунгалаг болон холбогдох бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмж цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор доор эрэмбэлэн үзүүлэв.

#### **1. Цалингийн дансны талаар**

##### **1.1 Илрүүлэлт:**

Тайлант жилийн 4, 9, 12 дугаар сарын цалингийн зардлыг түүвэрлэн аудитлахад:

4 ба 12 дугаар сард тус бүр нэг нийт 2 ажилтны бодогдсон цалингаас НДШ, ХХОАТ суутгагдалгүй олгогдсон байна.

Дээр дурдсан алдаанаас шалтгаалж, 227.01 мянган төгрөгийг ажилтанд илүү олгосон байна.

##### **1.2 Эрсдэл:**

Цалингийн зардал илүү дутуу тооцоологдсоноос санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд зардал илүү, дутуу илэрхийлэгдэх.

##### **1.3 Зөвлөмж:**

НДШ, ХХОАТ-ыг нөхөн суутгах. Цаашид цалингийн програмаар хийгдэж байгаа ажил гүйлгээг давтан шалгаж баталгаажуулж байх.

##### **1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

## **2. Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал**

### **2.1 Илрүүлэлт:**

Урсгал засварын ажил гүйцэтгүүлэхээр Честный Финанс ХХК-тай 1,512.6 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлсэн бөгөөд тухайн байгууллага нь гэрээнд 1,178.2 мянган төгрөгийг материалын зардалд, 334.5 мянган төгрөгийг ажлын хөлсөнд тооцхоор тусгасан байна. Хүүхдийн номын ордон энэ ажлын хөлснөөс ХХОАТ суутган тайлагнасан байна.

### **2.2 Эрсдэл:**

Энэ нь тухайн иргэнээс татварыг давхардуулан суутгасан байх.

### **2.3 Зөвлөмж:**

ХХОАТ-ын тухай хуулийн дагуу байгууллагатай хийсэн гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн тул тухайн байгууллагын ажилтнаас ХХОАТ-ыг суутган тооцохгүй ба ажил гүйцэтгэгч байгууллага тухайн ажилтны цалин хөдөлмөрийн хөлстэй хамтатган тооцон тайлагнах үүрэгтэй.

### **2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

## 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,101,832.91</b>	<b>12,769,759.05</b>
<b>МӨНГӨ</b>		
<b>АВЛАГА</b>	<b>53,153.90</b>	<b>229,734.04</b>
Бусад авлага	53,153.90	229,734.04
Ажиллагчидтай холбогдсон авлага	16,293.90	229,734.04
Байгууллагаас авах авлага	36,860.00	
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>16,048,679.01</b>	<b>12,540,025.01</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>8,842,309.00</b>	<b>7,536,130.00</b>
Тусгай зориулалтын материал	8,842,309.00	7,536,130.00
<b>Хангамжийн материал</b>	<b>7,206,370.01</b>	<b>5,003,895.01</b>
Бичиг хэргийн материал	2,427,130.00	3,465,675.00
Аж ахуйн материал	1,658,720.01	172,020.01
Бусад хангамжийн материал	3,120,520.00	1,366,200.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>459,972,311.31</b>	<b>524,857,885.01</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>459,972,311.31</b>	<b>524,857,885.01</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>459,815,744.66</b>	<b>524,857,885.01</b>
Авто тээврийн хэрэгсэл-анхны өртөг	21,000,000.00	21,000,000.00
Авто тээврийн хэрэгсэл-хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	(21,000,000.00)
Машин тоног төхөөрөмж/компьютер/- анхны өртөг	118,959,255.50	106,082,308.50
Машин тоног төхөөрөмж/компьютер/- хуримтлагдсан элэгдэл	(112,881,072.43)	(97,896,037.77)
Тавилга, аж ахуйн эд хогшил-Анхны өртөг	88,415,975.82	96,440,596.82
Тавилга, аж ахуйн эд хогшил-Хуримтлагдсан элэгдэл	(80,517,555.86)	(82,138,474.90)
Номын фонд	445,839,141.63	502,369,492.36
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>156,566.65</b>	<b>-</b>
Программ хангамж-Анхны өртөг	4,179,100.00	4,179,100.00
Программ хангамж-Хуримтлагдсан элэгдэл	(4,022,533.35)	(4,179,100.00)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>476,074,144.22</b>	<b>537,627,644.06</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>476,074,144.22</b>	<b>537,627,644.06</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>476,074,144.22</b>	<b>537,627,644.06</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	398,693,113.63	398,693,113.63
Өмч : - Төрийн	398,693,113.63	398,693,113.63
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>77,256,040.09</b>	<b>100,993,435.53</b>
Өмнөх үеийн үр дүн	77,256,040.09	73,880,306.52
Тайлант үеийн үр дүн		27,113,129.01
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,990.50	37,941,094.89
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>476,074,144.22</b>	<b>537,627,644.05</b>

## 4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>573,780,106.00</b>	<b>578,172,442.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>54,104,247.00</b>	<b>25,646,342.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>54,104,247.00</b>	<b>25,646,342.00</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	54,104,247.00	25,646,342.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,636,160.00	11,409,740.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	437,750.00	626,201.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,030,337.00	13,610,401.00
<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>519,675,859.00</b>	<b>552,419,100.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>491,909,100.00</b>	<b>516,582,200.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	491,909,100.00	516,582,200.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>27,327,100.00</b>	<b>35,836,900.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	7,592,400.00	8,597,600.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,695,000.00	23,979,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,039,700.00	3,260,300.00
Нийгмийн даатгалын сангаас	439,659.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>536,403,270.97</b>	<b>527,939,258.33</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>536,403,270.97</b>	<b>527,939,258.33</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>513,317,426.33</b>	<b>512,226,034.55</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>272,353,903.00</b>	<b>287,905,635.66</b>
Цалин	271,993,903.00	287,775,635.66
Шагнал урамшуулал	360,000.00	130,000.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,367,527.48</b>	<b>34,746,912.84</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,648,803.48	23,872,617.36
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,657,445.00	2,871,296.31
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,181,556.00	2,241,358.65
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	534,520.00	535,469.45
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,345,203.00	5,226,171.08
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>137,047,200.00</b>	<b>137,047,200.00</b>
Байрны түрээс	137,047,200.00	137,047,200.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,347,235.48</b>	<b>29,069,745.58</b>
Бичиг хэрэг	7,403,652.50	7,246,989.00
Тээвэр шатахуун	1,416,540.00	2,328,160.00
Шуудан холбоо, интернетийн төлбөр	3,791,879.98	5,695,661.58
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	550,000.00
Бага үнэтэй түргэн элдэгдэх зүйл	25,135,163.00	9,043,036.00
Бараа материал акалсны зардал	-	4,205,899.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,588,000.00</b>	<b>-</b>

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөөлөн эд хогшил, нормын хувцас худалдан авах зардал	1,588,000.00	-
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,069,100.00</b>	<b>357,994.00</b>
Урсгал засвар	1,069,100.00	357,994.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,383,700.00</b>	<b>2,580,800.00</b>
Дотоод томилолт	1,383,700.00	2,580,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,654,000.00</b>	<b>13,752,000.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,627,700.00	9,227,600.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээ	-	2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	95,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
Мэдээлэл технологийн үйлчлэгээ	897,400.00	800,000.00
Улсын мэдээллийн маягтийн зардал	907,000.00	1,501,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,506,760.37</b>	<b>6,765,746.47</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,377,450.00	3,260,300.00
Элэгдлийн зардал	16,129,310.37	3,505,446.47
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,085,844.64</b>	<b>15,713,223.78</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,734,305.10</b>	<b>10,624,820.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,208,800.00	9,020,600.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,525,505.10	1,604,220.00
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,351,539.54</b>	<b>5,088,403.78</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,351,539.54	5,088,403.78
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>37,376,835.03</b>	<b>50,126,183.67</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>23,013,054.66</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	23,013,054.66
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	-	<b>(23,013,054.66)</b>
<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>37,376,835.03</b>	<b>27,113,129.01</b>

#### 4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 1-р сарын 1-ний өдрөөрх үлдэгдэл</b>	<b>398,693,113.63</b>	<b>124,990.50</b>	<b>39,879,205.06</b>	<b>438,697,309.19</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>398,693,113.63</b>	<b>124,990.50</b>	<b>39,879,205.06</b>	<b>438,697,309.19</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Тайлант үеийн үр дүн			37,376,835.03	37,376,835.03
<b>2017 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>	<b>398,693,113.63</b>	<b>124,990.50</b>	<b>77,256,040.09</b>	<b>476,074,144.22</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,375,733.56)	(3,375,733.56)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>37,816,104.39</b>		<b>37,816,104.39</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		37,816,104.39		37,816,104.39
Тайлант үеийн үр дүн			27,113,129.01	27,113,129.01
<b>2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>	<b>398,693,113.63</b>	<b>37,941,094.89</b>	<b>100,993,435.53</b>	<b>537,627,644.05</b>

#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Дүн	
	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>530,749,769.00</b>	<b>564,787,816.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,073,910.00</b>	<b>12,368,716.00</b>
Нийтлэг татварын бус орлого	11,073,910.00	12,368,716.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,073,910.00	12,368,716.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,636,160.00	11,742,515.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	437,750.00	626,201.00
<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>519,675,859.00</b>	<b>552,419,100.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>491,909,100.00</b>	<b>516,582,200.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	491,909,100.00	516,582,200.00
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>27,327,100.00</b>	<b>35,836,900.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	7,592,400.00	8,597,600.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	15,695,000.00	23,979,000.00
Төсвийн байгууллагын ажил үйлчилгээний нэмэлт орлого	4,039,700.00	3,260,300.00
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>439,659.00</b>	-
Нийгмийн даатгалын сангаас	439,659.00	-
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>501,087,840.00</b>	<b>521,434,516.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>501,087,840.00</b>	<b>521,434,516.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>477,985,700.46</b>	<b>505,721,292.22</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>272,732,138.06</b>	<b>288,338,204.00</b>
Үндсэн цалин	246,845,538.06	218,815,151.00
Нэмэгдэл	-	28,339,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	17,168,200.00	40,320,000.00
Урамшуулал	360,000.00	864,053.00
Гэрээт ажлын хөлс	8,358,400.00	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,859,932.42</b>	<b>34,826,062.64</b>
Нийгмийн даатгалын шимтгэл	20,141,208.42	23,879,262.64
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,657,445.00	2,736,700.00
ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	2,181,556.00	2,189,400.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	534,520.00	547,300.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,345,203.00	5,473,400.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>137,047,200.00</b>	<b>137,047,200.00</b>
Байрны түрээс	137,047,200.00	137,047,200.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,016,979.98</b>	<b>20,150,325.58</b>
Бичиг хэргийн материал	7,066,950.00	7,113,234.00
Тээвэр шатахуун	1,453,400.00	2,291,300.00
Шуудан холбоо	3,791,879.98	5,695,661.58
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	600,000.00	550,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,104,750.00	4,500,130.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,764,000.00</b>	<b>1,645,100.00</b>
Нормын хувцас, Зөөлөн эдлэл	1,764,000.00	1,645,100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,757,000.00</b>	<b>3,022,600.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	-	66,000.00

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урсгал засварын зардал	2,757,000.00	2,956,600.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,383,700.00</b>	<b>2,580,800.00</b>
Дотоод томилолт	1,383,700.00	2,580,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,047,300.00</b>	<b>14,850,700.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,845,000.00	10,326,300.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл		2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	95,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,073,400.00	800,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлдэх	907,000.00	1,501,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,377,450.00</b>	<b>3,260,300.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,377,450.00	3,260,300.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,102,139.54</b>	<b>15,713,223.78</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,750,600.00</b>	<b>10,624,820.00</b>
Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж	7,208,800.00	9,020,600.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,541,800.00	1,604,220.00
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,351,539.54</b>	<b>5,088,403.78</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,351,539.54	5,088,403.78
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)</b>	<b>29,661,929.00</b>	<b>43,353,300.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,671,599.00</b>	<b>43,353,300.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,671,599.00</b>	<b>43,353,300.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>29,671,599.00</b>	<b>43,353,300.00</b>
Биет олон биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,671,599.00	43,353,300.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(29,671,599.00)</b>	<b>(43,353,300.00)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(9,670.00)</b>	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,670.00	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>				
<b>1.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2+5)</b>	<b>523,082,200.00</b>	<b>519,887,177.22</b>	<b>3,195,022.78</b>	<b>99.4%</b>
<b>2.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (3+4)</b>	<b>523,082,200.00</b>	<b>519,887,177.22</b>	<b>3,195,022.78</b>	<b>99.4%</b>
<b>3.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>523,082,200.00</b>	<b>519,887,177.22</b>	<b>3,195,022.78</b>	<b>99.4%</b>
<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>514,061,600.00</b>	<b>510,866,577.22</b>	<b>3,195,022.78</b>	<b>99.4%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>283,395,800.00</b>	<b>280,260,689.00</b>	<b>3,135,111.00</b>	<b>98.9%</b>
Үндсэн цалин	214,002,700.00	210,867,636.00	3,135,064.00	98.5%
Нэмэгдэл	28,339,000.00	28,339,000.00	-	100%
Унаа болон бусад нөхөн олговор	40,230,000.00	40,230,000.00	-	100%
Урамшуулал	734,100.00	734,053.00	47.00	100%
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>34,007,500.00</b>	<b>33,958,462.64</b>	<b>49,037.36</b>	<b>99.9%</b>
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	23,060,700.00	23,011,662.64	49,037.36	99.8%
Тэтгэмжийн даатгал	2,736,700.00	2,736,700.00	-	100%
ҮОМШӨ-ний даатгал	2,189,400.00	2,189,400.00	-	100%
Ажилгүйдлийн даатгал	547,300.00	547,300.00	-	100%
Эрүүл мэндийн даатгал	5,473,400.00	5,473,400.00	-	100%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>137,047,700.00</b>	<b>137,047,200.00</b>	<b>500.00</b>	<b>100%</b>
Байрны түрээс	137,047,700.00	137,047,200.00	500.00	100%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,568,000.00</b>	<b>45,566,825.58</b>	<b>1,174.42</b>	<b>100%</b>
Бичиг хэргийн материал	3,500,000.00	4,529,734.00	(1,029,734.00)	129.4%
Тээвэр, шатахууны зардал	2,500,000.00	2,291,300.00	208,700.00	91.7%
Шуудан холбооны зардал	6,067,800.00	5,695,661.58	372,138.42	93.9%
Ном хэвлэлийн зардал	28,000,000.00	28,000,000.00	-	100%
Хог хаягдал устгах цэвэрлэх	1,000,000.00	550,000.00	450,000.00	55%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	4,500,200.00	4,500,130.00	70.00	100%
<b>Нормативт зардал</b>	<b>1,645,100.00</b>	<b>1,645,100.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах	1,645,100.00	1,645,100.00	-	100%
<b>Эд хогшил худалдан авах зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
Урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,590,000.00</b>	<b>2,580,800.00</b>	<b>9,200.00</b>	<b>99.6%</b>
Гадаад албан томилолт				
Дотоод албан томилолт	2,590,000.00	2,580,800.00	9,200.00	99.6%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>7,307,500.00</b>	<b>7,307,500.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2,783,100.00	2,783,100.00	-	100%
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100%
Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00	-	100%
Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	95,000.00	-	100%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	-	100%
Мэдээлэл технологийн үйлчлгээ	800,000.00	800,000.00	-	100%

Хүүхдийн төв номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,501,000.00	1,501,000.00	-	100%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,020,600.00</b>	<b>9,020,600.00</b>	-	<b>100%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,020,600.00</b>	<b>9,020,600.00</b>	-	<b>100%</b>
Тэтгэвэрт гаргахад нь олгох нэг удаагийн тэтгэмж	9,020,600.00	9,020,600.00	-	100%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	-	-	-	
<b>4.3АРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>523,082,200.00</b>	<b>519,887,177.22</b>	<b>3,195,022.78</b>	<b>99.4%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>516,582,200.00</b>	<b>512,122,477.22</b>	<b>4,459,722.78</b>	<b>99.1%</b>
Улсын төсвөөс санхүүжих	516,582,200.00	512,122,477.22	4,459,722.78	99.1%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,500,000.00	7,764,700.00	(1,264,700.00)	119.5%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
<b>Нэмэлт санхүүжилт</b>				
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж				
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>				
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>Байгууллагын тоо</b>				
<b>Ажиллагсад бүгд</b>	<b>32</b>	<b>32</b>		<b>100%</b>
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	23	23		100%
Үйлчлэх ажилтан	8	8		100%
Гэрээт ажилтан				

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>			-	
<b>1.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35,834,420.00</b>	<b>35,834,420.00</b>	-	<b>100%</b>
<b>2.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (3+4)</b>	<b>35,834,420.00</b>	<b>35,834,420.00</b>	-	<b>100%</b>
<b>3.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>35,834,420.00</b>	<b>35,834,420.00</b>	-	<b>100%</b>
<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>34,230,200.00</b>	<b>34,230,200.00</b>	-	<b>100%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>7,360,000.00</b>	<b>7,360,000.00</b>	-	<b>100%</b>
Үндсэн цалин	7,230,000.00	7,230,000.00	-	100%
Урамшуулал	130,000.00	130,000.00	-	100%
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>867,600.00</b>	<b>867,600.00</b>	-	<b>100%</b>
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	867,600.00	867,600.00	-	100%
<b>Бараа ажил үйлчилгээний урсгал зардал</b>	<b>5,583,500.00</b>	<b>5,583,500.00</b>	-	<b>100%</b>
Бичиг хэргийн материал	2,583,500.00	2,583,500.00	-	100%
Ном, хэвлэл	3,000,000.00	3,000,000.00	-	100%
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>10,523,600.00</b>	<b>10,523,600.00</b>	-	<b>100%</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,067,000.00	1,067,000.00	-	100%
Тавилга	9,000,000.00	9,000,000.00	-	100%
Урсгал засвар	456,600.00	456,600.00	-	100%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс</b>	<b>9,895,500.00</b>	<b>9,895,500.00</b>	-	<b>100%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,895,500.00	9,895,500.00	-	100%
<b>4.УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,604,220.00</b>	<b>1,604,220.00</b>	-	<b>100%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,604,220.00</b>	<b>1,604,220.00</b>	-	<b>100%</b>
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,604,220.00	1,604,220.00	-	100%
<b>5.ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,834,420.00</b>	<b>35,834,420.00</b>	-	<b>100%</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,834,420.00</b>	<b>35,834,420.00</b>	-	<b>100%</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,597,600.00	8,597,600.00	-	100%
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,979,000.00	23,979,000.00	-	100%
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,257,820.00	3,257,820.00	-	100%
Бусад	-	-	-	-
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>			-	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	-	-	-
Байгууллагын тоо				
<b>Ажиллагсад бүгд</b>	<b>32</b>	<b>32</b>		<b>100%</b>
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	23	23		100%
Үйлчлэх ажилтан	8	8		100%
Гэрээт ажилтан				

#### 4.7 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Бүртгэлийн дансны нэр		Дүн
<b>А</b>	<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ОРЛОГО (ҮАО+ХҮАО+СҮАО)</b>	<b>564,787,816.00</b>
	Хасах нь	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,977,815.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	626,201.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	484,387,78
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-
<b>Б</b>	<b>Тохируулсан орлогын дүн</b>	<b>5,088,403.78</b>
<b>В</b>	<b>ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ОРЛОГЫН ДҮН (А-Б)</b>	<b>559,699,412.22</b>
<b>Г</b>	<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРЛАГА (ҮАО+ХҮАО+СҮАО)</b>	<b>564,787,816.00</b>
210101	Үндсэн цалин	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	
210105	Гэрээт ажлын цалин	
210201	Тэтгэвэрийн даатгал	
210304	Байрны түрээс	
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	
210403	Шуудан, холбоо интернэтийн төлбөр	
210404	Ном, хэвлэл	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	
210604	Урсгал засвар	
210702	Дотоод албан томилолт	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	
210803	Даатгалын Үйлчилгээ	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	
210806	Мэдээлэл, технологийн зардал	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	
21090102	Бараа үйлчилгээний бусад зардал	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /Улсын төсөв/	5,088,403.78
312113	Төсөвт байгууллагын харилцах төгрөг	
<b>Д</b>	<b>Тохируулсан зарлагын дүн</b>	<b>5,088,403.78</b>
	<b>ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАРЛАГЫН ДҮН (Г-Д)</b>	<b>559,699,412.22</b>
	<b>Тохируулгын орлого, зарлагын зөрүү (Б-Д)</b>	<b>-</b>

### 1.6. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b> 2019.02.22	<b>Аудитын нэр:</b>	<b>Хүүхдийн төв номын сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b> САГ-2019/25/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Хүүхдийн төв номын сан</b>		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
					Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	8	9	10
1	Нэгтгэл хийхэд 2 хүний НДШ-ийг суутгаагүй олгосон. Материаллаг бус дүнтэй. Тухайн ажилтнууд 2019 оны 2-р сарын цалин дээрээсээ суутгуулахаар зөвшөөрсөн.	134.71	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Оюунтунгалаг
2	Нэгтгэл хийхэд 2 ажилтны ХХОАТ-ыг суутгаагүй олгосон. Материаллаг бус дүнтэй. Тухайн ажилтнууд 2019 оны 2-р сарын цалин дээрээсээ суутгуулахаар зөвшөөрсөн.	92.31	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Оюунтунгалаг
3	Урсгал засварын ажил гүйцэтгэсэн Честный Финанс ХХК-ийн ажлын хөлсөнд ногдох дүнгээс ХАОАТ суутгасан. Материаллаг бус дүнтэй.	33.45	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Оюунтунгалаг
		260.46				